



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 7/209

Дадал сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний
танхимын дуудлага худалдааг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний танхимын дуудлага худалдааг 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 09.00-15.00 цагийн хооронд зохион байгуулсугай.

2. Газруудын зориулалт, хэмжээ, анхны үнэ, дэнчингийн хэмжээ, эзэмшүүлэх хугацаа, дуудлага худалдаа эхлэх цагийн хуваарийг доорхи дурьдсанаар тогтоосугай.

- Баян-Овоо /4-р баг/, Чингисийн тоонот хаалганы зүүн урд орон нутгийн чанартай аялал, жуулчлалын газар байгуулах зориулалттай 5000 м² газрын анхны үнэ 4.000.000 төгрөг, дэнчингийн хэмжээ 400.000 төгрөг, эзэмшүүлэх хугацаа 60 жил, дуудлага худалдаа 09 цаг 00 минутанд эхлэх,

- Баян-Овоо /4-р баг/ Хусан төгөлийн хойно орон нутгийн чанартай аялал, жуулчлалын газар байгуулах зориулалттай 5000 м² газрын анхны үнэ 4.000.000 төгрөг, дэнчингийн хэмжээ 400.000 төгрөг, эзэмшүүлэх хугацаа 60 жил, дуудлага худалдаа 09 цаг 00 минутанд:

3. Газрын цахим дуудлага худалдааг зохих хууль тогтоомжийн дагуу баримт бичгийг бүрдүүлж зохион байгуулахыг Газрын даамал (Б.Урансайхан)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/145 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000487